



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар A/66


Улаанбаатар хот

Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны A/127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 02 сарын 23 өдрийн  
А/6 дугаар тушаалын хавсралт



## ХҮНИЙ ЭМИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	Төрийн нарийн бичгийн дарга
Орлогч дарга:	Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга;
Нарийн бичгийн дарга:	Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн Эмийн сонголт, бүртгэл, зохистой хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтэн;
Гишүүд:	Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга;  Дотрын ерөнхий мэргэжилтэн;  Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн;  Эм зүй, эм судлалын ерөнхий мэргэжилтэн;  Мэс заслын ерөнхий мэргэжилтэн;  Уламжлалт анагаах ухаан судлалын ерөнхий мэргэжилтэн;  Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хангамж, хяналт, эмийн сан хариуцсан мэргэжилтэн Д.Болдбаатар;  Шинжлэх ухааны академи, Монголын анагаах ухааны Академийн гишүүн, Академич, Эмзүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Дүнгэрдорж /зөвшилцсөнөөр/;  Монголын Анагаах ухааны академийн гишүүн, Вирус судлалын нийгэмлэгийн Дэд тэргүүн, Биологийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Оюунбилэг /зөвшилцсөнөөр/;  Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ерөнхий аудитор П.Цэдэн /зөвшилцсөнөөр/;  Клиник эм судлаач, Анагаах ухааны доктор, профессор Г.Чойжамц /зөвшилцсөнөөр/;

Эмзүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоо  
Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн  
гишүүн О.Дамба /зөвшилцсөнөөр/;

Эмзүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоо  
Төрийн бус байгууллагын төлөөлөл Л.Алтанцогт  
/зөвшилцсөнөөр/;

-----xxxxx-----